

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	1
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл.....	1
1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт	1
1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт	3
1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт	4
1.2.1 Ордын нөөц	4
1.2.2 Орд газрын ашиглалтын одоогийн байдал.....	1
1.2.3 Ирээдүйн уурхайн ашиглалтын үе.....	1
1.3 Төслийн үйл ажиллагаа	2
1.3.1 Ил уурхай	2
1.3.2 Ил уурхайн тоног төхөөрөмж.....	2
1.3.3 Үйлдвэрлэлийн нөөц	3
1.4 Баяжуулах боловсруулах технологи	4
1.4.1 Баяжуулах үйлдвэр	4
1.4.2 Хайлуур жоншны хүдэр баяжуулах технологи	4
1.4.3 Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж	7
1.5 Хаягдлын аж ахуй	9
1.5.1 Ил уурхайн хүчин чадал, ажиллах горим, ашиглалтын хугацаа.....	11
1.5.2 Өрөмдлөг, тэсэлгээ	14
1.6 Дэд бүтэц	15
1.6.1 Уурхайн барилга байгууламж	15
1.6.2 Цахилгаан хангамж	16
1.6.3 Дулаан хангамж	16
1.6.4 Усан хангамж	16
1.7 Төслийн эцсийн бүтээгдэхүүн	16
1.7.1 Элементийн шинжилгээ, металлын баланс.....	16
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
2.1 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	1
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	3
3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	3
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ.....	5

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	6
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	22
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
14. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-016940 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн цэгүүд.....	3
Хүснэгт 2. Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн талбайн цэгүүд	3
Хүснэгт 3. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	1
Хүснэгт 4. Ил уурхайн технологи	2
Хүснэгт 5. Уулын ажлын механикжуулалтын бүтэц	2
Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн технологи	5
Хүснэгт 7. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж.....	8
Хүснэгт 8. Баяжмал усгүйжүүлэх тоног төхөөрөмж.....	8
Хүснэгт 9. Хаягдал усгүйжүүлэх хэсгийн тоног төхөөрөмж	8
Хүснэгт 10. Уулын ажлын механикжуулалтын бүтэц	10
Хүснэгт 11. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс	10
Хүснэгт 12. Ажлын горим.....	11
Хүснэгт 13. Уурхайн хажуугийн өнцөг	11
Хүснэгт 14. Календарчилсан төлөвлөгөө	12
Хүснэгт 15. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим.....	13
Хүснэгт 19. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	3
Хүснэгт 20. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал...5	
Хүснэгт 21. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	6
Хүснэгт 24. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 25. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 26. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 27. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
Хүснэгт 28. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт 29. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	26

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны нэгжийн зураг.....	2
Зураг 2. Цагаан чулуут нэртэй хайлуур жоншны ордын байршил.....	2
Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн байршил	3
Зураг 4. Ил уурхайн өнөөгийн төрх хээрийн судалгааны үед.....	1
Зураг 5. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем	7
Зураг 6. Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хээрийн судалгааны үед DJI air drone 2025-07-04	7
Зураг 7. Хаягдал хадгалах байгууламжийн бүтээн байгуулалтын ажил хээрийн судалгааны үед DJI air drone 2025-07-04.....	10

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

Төслийн нэр :	“Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төсөл.
Төсөл хэрэгжүүлэгч :	Шашир-Оргил ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011064060 Регистрийн дугаар: 5106753 Тусгай зөвшөөрлийн дугаар : MV-016940 Захирал: Утас: 94876634, 99088656
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, 18-р хороо, Стадион оргил, их монгол улс, 219 байр, 703 тоот

Үндсэн үйл ажиллагаа. “Шашир-Оргил” ХХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээгээр “Ашигт малтмал ашиглах” үндсэн үйл ажиллагаатай.

Ашигт малтмалын нөөцтэй холбоотой баримт бичгүүд.

1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт


“MV-016940 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн хойшоо 485 км, Хэнтий аймгийн Батноров сумын төвөөс зүүн хойш 45 км, Норвлин сум явах замд байрлах Өлзийт сайхан уулын энгэрт Зүүн харзтайн булагийн эхэнд, “Цагаан чулуут уул” нэртэй газар оршино.

“Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр” нь Улаанбаатар хотоос зүүн хойшоо 440 км, Хэнтий аймгийн Батноров сумын төвөөс хойш 11 км, Норвлин сум явах замын хойд талд “Цагаан чулуут уул” нэртэй ордоос баруун тийш 40км зайд байрлана.


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он



Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны нэгжгийн зураг



Зураг 2. Цагаан чулуут нэртэй хайлуур жоншны ордын байршил



Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн байршил

Хүснэгт 1. MV-016940 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн цэгүүд

№	Талбайн хэмжээ	Уртраг	Өргөрөг
1	212.91 га	111° 41' 05"	48° 20' 15"
2		111° 39' 58"	48° 20' 15"
3		111° 39' 58"	48° 21' 05"
4		111° 41' 05"	48° 21' 05"

Хүснэгт 2. Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн талбайн цэгүүд

№	Талбайн хэмжээ	Уртраг	Өргөрөг
1	20 га	111° 26' 33.78"	48° 02' 01.98"
2		111° 26' 33.78"	48° 02' 18.50"
3		111° 26' 53.29"	48° 02' 18.39"
4		111° 26' 53.29"	48° 02' 01.97"

1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

Уурхайгаас баяжуулах үйлдвэр 40 км зайтай тул ажилчдын байрыг тус тусад нь байрлахаар төлөвлөж өгсөн бөгөөд баяжуулах үйлдвэрийн ажилчдын байр нь баяжуулах үйлдвэрээс баруун зүгт 300 м зайд, 0.5 га талбайг эзлэн байрлана. Тосгон нь оффис, 90 хүний багтаамжтай ажилчдын байр, харуулын байр зэрэг байгууламжаас бүрдэнэ. Ажилчдын байранд халуун усны газар зэргийг байгуулна.

Төсөлд шаардлагатай хүний нөөц. Уурхайд захиргаа удирдлагын хэсэгт 11 хүн, Уурхайн хэсэгт 56 хүн, Засвар механикийн цех 16 хүн, Аж ахуйн хэсэг 10 хүн, нийт 93 хүний ажлын байр бий болгох бөгөөд уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох эдгээр хүмүүсийн ая тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

1.2.1 Ордын нөөц

“Цагаан чулуут уул” нэртэй хайлууур жоншны ордын нөөцийг Монгол улсын ЭБМЗийн 2011 оны 01-р сарын 27-ны өдрийн ХХ-02-07 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2011 оны 02-р сарын 14-ний өдрийн 43 тоот тушаалаар хүдрийн бодитой В зэргээр 419.15 мян.тн, боломжтой С зэргээр 812.79 мян.тн нийт бодитой болон боломжтой В+С зэргээр 1231.93 мян.тн-оор, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.


Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Хүснэгт 3. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

“Цагаан чулуут уул” ордын нөөцийн дахин тооцооны нэгдсэн хүснэгт (2010 оны 10 сарын 01-ний байдлаар)											
№	Хүдрийн биетийн дугаар	Блокийн дугаар	Нөөцийн зэрэглэл	Хэсэгшилийн Талбай, S, /м ² /	Хүдрийн биетийн жинхэнэ зузаан, m, /м/	Эзэлхүүн, V, м ³	Хувийн жин	Хүдрийн нөөц Q, /тн/	Дундаж агуулга, C, /%/	Эрдсийн нөөц, P, /тн/	
1		В-1	В	4484.17	3.8	17039.846	2.6	44303.6	37.3	16503.1	
2		В-2		7389.723	4.75	35101.1843	2.6	91263.1	29.8	27232.9	
3		В-3		9082.148	4.8	43594.3104	2.6	113345.2	26.0	29481.4	
4		В-4		6276.465	3.8	23850.567	2.6	62011.5	25.1	15577.3	
5		В-5		5613.4	6.3	35364.42	2.6	91947.5	21.1	19382.5	
6		В-6		869.528	7.2	6260.6016	2.6	16277.6	16.9	2754.2	
		Нийт			33715.434	30.65	161210.929	2.6	419114.84	26.5	110931.1
		Дундаж				4.78					
7		С-1	С	15093.06	5.2	78483.912	2.6	204058.2	37.3	76011.7	
8		С-2		25329.9	6.9	174776.31	2.6	454418.4	38.7	175859.9	
9		С-3		8727.921	6.8	59349.8629	2.6	154309.6	37.3	57557.5	
		Нийт			49150.881	18.9	312610.085	2.6	812786.2	38.1	309429.1
		Дундаж									
		Бүгд		В+С	82866.315	5.72	473821.014	2.6	1231901.04	34.1	420360.1

1.2.2 Орд газрын ашиглалтын одоогийн байдал

“Шашир Оршил” ХХК нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны орд нь 2020 оноос өмнө үйл ажиллагаа явуулж байгаагүй. 2020 онд олборлолт явуулж, В-I, В-II, В-IV, В-V зэрэглэлийн хэсэгшилээс 65.97 мян.м3 хүдэр олборлосон байна.



Зураг 4. Ил уурхайн өнөөгийн төрх хээрийн судалгааны үед

1.2.3 Ирээдүйн уурхайн ашиглалтын үе

Уурхай нь өмнөх жилүүдэд уурхайг нээж олборлолт хийгдсэн тул шинээр нээгч тараншей нэвтрэх шаардлагагүй. Ил уурхайн ахилтаар шинээр хэлбэржих доголдуудын зам талбай нь шууд гадаргууд гарах бололцоог бүрдүүлэх тул ашиглалтын 1-р жилд догол хооронд траншей тавих шаардлагагүй. Харин 2-р жилд 1290-1270 м-ийн түвшинг хүртэл 2 траншей нэвтрэнэ. Ашиглалтын 3-р жилд 1250 м-ийн түвшин хүртэл, нэвтрэх байнгын 5 траншей байна. Хүдрийн биетийн агуулга суналын дагуу хувиралтай үргэлжлэх тул уурхайгаас гарах жоншны дундаж агуулгыг тогтвортой байлгах шарлагатайг. Тиймээс хүдрийн биетийг суналын дагуу бүрэн нээж, олборлолтыг аль ч хэсэгт явуулахад бэлэн болгоно. Ашиглалтын үед баримтлах нэг гол зүйл нь хөрс болон хүдрийн доголдуудыг уурхайн загварчлалаар тусгагдсан эцсийн байдалд нь үргэлжид хүргэж явах бөгөөд энэ нь нэг доголд дахин ажил хийгдэхгүй болно. Тиймээс хүдрийн биетийн гаршнаас эхлэн ул талд нь уурхайн ажлын бус доголыг үлдээх замаар ашиглалтыг явуулна. Хүдрийн биетийн ул талын шугамын чиглэл нь гадаргын өгсөх хэсэгт чиглэх тул (уналын чиглэл нь баруун хойноос зүүн урагш) уурхайн ахилтыг гадаргын намсах тал руу чиглүүлнэ.

1.3 Төслийн үйл ажиллагаа

1.3.1 Ил уурхай

Ил уурхайн технологи. Ашигт малтмалыг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай ба иж бүрнээр ашиглах, нөөцийг бүрэн гүйцэд авах нөхцөлийг хангасан ашиглалтын системийн хангах шаардлагын үндсэн дээр ордыг ил уурхайн аргаар ашиглахаар төсөлд тусгалаа.

Ил уурхайн ашиглалтын системийн ангиллаас таамаглаж буй нөхцөл байдалд ордыг ашиглахад хамгийн тохиромжтой хувилбарыг Академич Н.В.Мельников болон В.В.Ржевскийн ангиллаас сонголтыг хийлээ.

Хүснэгт 4. Ил уурхайн технологи

№	Үндсэн технологи	Технологийн ажилбар
1	Тэсэлгээ:	Хөрс болон хүдрийг тэсэлгээний аргаар сийрэгжүүлэх бөгөөд тэсэлгээ, өрөмдлөгийн ажлыг гэрээт туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлэх ба өрөмдлөгийн ажилд YUCHAI үйлдвэрийн JC860 маркийн өрмийн машин ашиглана. Өрмийн машин нь хоногт 2 ээлжээр, нэг ээлжид 10 цагаар ажиллана. Өрөмдлөгийн ажилд 1 машин ажиллах бөгөөд нэг ээлжид 45 цооног өрөмдөх хүчин чадлаар ажиллана. Өрөмдлөг тэсэлгээний ажлыг 9 хоногт 1 удаа хийх ба нэг удаагийн тэсэлгээний блокийн эзлэхүүн нь 40000 м3 байна.
2	Ухаж ачих процесс:	Цагаан чулуут уулын хайлуур жоншны ордод уулын цулаар эхний жил хамгийн их 1405 мян.м3 олборлолт явуулахаар байна. Ил уурхайд хөрс болон хүдрийн мөргөцөгт “Шашир-Оргил” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу 3.2 м3 болон 4.8 м3 утгуурын багтаамж бүхий 2 ш экскаватор байхад хангалттай байна
3	Тээвэрлэх процесс:	БНХАУ-д үйлдвэрлэсэн 50 тн, 25 тн даацтай HOWO маркийн 2, 2 ш буюу нийт 4 ш автосамосвалыг худалдан авахаар төлөвлөлөө. Автосамосвалаар хүдрийг 1.0 км зайд байрлах түр овоолгын талбайд тээвэрлэнэ..
4	Хөрсний овоолго:	Уурхайн жилд хуулах хөрсний хэмжээ 1347.3 мян.м3 бөгөөд хөрсний сийрэгжилтийг дундаар 1.3 гэж үзвэл нийт 1751.49 мян.м3 болно. Хөрсний овоолгын талбайг уурхайн зүүн урд талд сонгож авсан бөгөөд дунджаар 1 км зайнд тээвэрлэнэ. Хөрсний овоолгыг дунджаар 15 м өндөртэй 2 доголоор байгуулна. Овоолго байгуулах талбай нь налуу газар юм. Овоолгын ерөнхий налуугийн өнцгөөс хамааруулан 370 байхаар тооцсон болно. Ашиглалтын жилүүдэд нийт 22.02 га талбайд шимт хөрс хуулалтын ажил гүйцэтгэх бөгөөд энэ нь 44.0 мян.м3 үржил шимт хөрс хуулж хадгална.
5	Хүдрийн овоолго:	Ил уурхайгаас олборлосон хүдрийг хүдэр буулгах талбайд овоолго үүсгэн хураана. Уурхайгаас ашиглалтын хугацаанд хаягдал бохирдол тооцоноор нийт 27.9 сая.тн анхдагч хүдэр олборлон хүдрийн агуулахын талбайд хураана.

1.3.2 Ил уурхайн тоног төхөөрөмж

Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Хүдэр болон хөрсний чулуулгийн шинж чанар бат бэхийн үзүүлэлт, ил уурхайн хэлбэр хэмжээ зэрэгт тулгуурлан уулын ажлын механикжуулалтын бүтцийг дараах байдлаар тодорхойллоо.

Хүснэгт 5. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Уулын ажил	Хөрс хуулалт	Хүдэр олборлолт	Шимт Хөрс хуулалт
Ухаж ачихад бэлдэх	ӨТА	ӨТА	ӨТА
Ухаж ачих	Экскаватор	Экскаватор	Экскаватор
Тээвэрлэлт	Автосамосвал	Автосамосвал	Автосамосвал
Овоолго	Бульдозер	Утгуурт ачигч	Бульдозер
Гадаад тээвэр	-	Автомашин	-

Ил уурхайд хөрс болон хүдрийн мөргөцөгт “Шашир-Оргил” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу 3.2 м³ болон 4.8 м³ утгуурын багтаамж бүхий 2 ш экскаватор байхад хангалттай байна. Иймд төсөл захиалагч компанийн техникийн даалгаврын дагуу Hyundai R520LC-9 болон Hyundai R850LC-9 экскаваторыг түрээслэхээр ашиглахаар сонгосон байна.

“Шашир-Оргил” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу БНХАУ-д үйлдвэрлэсэн 50 тн, 25 тн даацтай HOWO маркийн 2, 2 ш буюу нийт 4 ш автосамосвалыг худалдан авахаар төлөвлөлөө.

Овоолго дээр буулгасан хөрсийг бульдозероор тарааж тэгшлэнэ. Бульдозерийг овоолгын хажууг налуулах, хэлбэршүүлэх ажлуудад ашиглана. Овоолгод ажиллах D65E бульдозер сонгосон байна.

Ашиглалтын хугацаанд уурхайд D65E маркийн бульдозер нь хоногт 1314.27 м³/хоног хүчин чадалтайгаар ажиллах бөгөөд ашиглалтын жилд 4 ш ажиллахад уурхайн бүтээл болон хэрэгцээг бүрэн хангахаар байна. Хүдрийн овоолго дээр буулгасан хүдрийг утгуурт ачигчаар тарааж тэгшлэнэ. Хүдрийн овоолгод ажиллах ZL50C утгуурт ачигчийг ёнгосон.

Ашиглалтын хугацаанд уурхайн хүдрийн овоолгод ZL50C маркийн утгуурт ачигч нь ш 1 хоногт 817.7 м³/хоног хүчин чадалтайгаар ажиллах бөгөөд ашиглалтын жилд 1 ш ажиллахад уурхайн бүтээл болон хэрэгцээг бүрэн хангахаар байна.

1.3.3 Үйлдвэрлэлийн нөөц

“Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ил уурхайн хаягдал, бохирдлын хувь хэмжээг хүдрийн биетийн уналын өнцөг, тогтоц, зузаан, олборлолтын доголын өндөр зэрэг хүчин зүйлүүдээс хамааруулж ОХУ-ын Уул уурхайн хүрээлэнгийн ил уурхайн хаягдал бохирдлын бүртгэл нормчлолд, тэдгээрийн харьцаа тооцох аргаар тооцов.

Хүдрийн биетийн дундаж налуу 65 градус бөгөөд ажлын доголын өндөр 10 м ба налуугийн өнцөг 65 градус байна.

Ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Ил уурхайд хүрээнд хамаарах геологийн нөөцийг олборлохын тулд дээрх тооцооны дагуу хаягдал, бохирдол үүснэ. Энэхүү нөөцөд тулгуурлан Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот “Ангилал, заавар батлах тухай” тушаалыг үндэслэн ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийж дараах хүснэгтэд харууллаа. Ил уурхайн хүрээнд өртөх болон хүрээний гадна үлдэх нөөцийн тооцоог түвшингээр ялгаж харууллаа.

Тус ордын нөөцийг АМГ-ын даргын 2011 оны 02-р сарын 14-ний өдрийн 43 тоот тушаалаар улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэл бүртгүүлсэн байна. Уг нөөц хүлээн авч бүртгэх тухай тушаалд ордын бодитой (В) зэргийн нөөцийг үндэслэн ТЭЗҮ-ийг боловсруулах боломжтой гэснийг үндэслэн ордын (В) нөөцийг бүрэн ашиглахаар үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо хийхэд үйлдвэрлэлийн нийт нөөц хаягдал ба бохирдол тооцсоноор хүдрээр 401.46 мян.тн, эрдсээр 109.68 мян.тн болж байна.

Нийт ил уурхай хүрээнд өртөх бодитой В зэрэглэлийн нөөц болон ил уурхайн хүрээнд зайлшгүй өртөх боломжтой С зэрэглэлийн нөөцөөс ашиглалтын үеийн хаягдал болон бохирдлыг тооцсоноор ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц бодитой В зэрэглэлээр 353.93 мян. тн, боломжтой С зэрэглэлийн 47.54 мян.тн, нийт 401.46 мян.тн хүдэр олборлохоор байна.

1.4 Баяжуулах боловсруулах технологи

1.4.1 Баяжуулах үйлдвэр

Хүдрийн биетүүдээс авсан дээжүүдэд хийсэн химийн шинжилгээгээр хүдрийн биетүүд нь CaF₂ 18-83.0%, SiO₂ 14.8-51.3%, CaCO₃ 0.1-3.6% хүрдэг байна. Гэрлийн шинжилгээгээр хүхрийн агуулга бараг байхгүй, харин фосфорын агуулга 0.01-0.1%-аас хэтэрдэггүй. Кварц-флюоритын хүдэрт флюоритын агуулга 20-69% бөгөөд энд флюорит ногоон, ягаан зэрэг өнгөтэй тааралдаж байна.

Баяжуулах үйлдвэр нь цахилгаан хангамж, шугам сүлжээнээс шалтгаалан хүдэр өөрийн эзэмшлийн MV-016940 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордооснийлүүлэх ордоосоо ойролцоогоор 40 гаруй км зайд буюу Хэнтий аймгийн Батноров сумын чанх хойд талд 11 км зайд байрлах юм.

Баяжуулах үйлдвэрийн түүхий эд хангамжийг “Цагаан Чулуут Уул” нэртэй орд болон баяжуулах үйлдвэрээс 0.4 км зайд орших “Бор-Өндөр Уул” ХХК-ийн уурхайгаас хангах юм.

Баяжуулах үйлдвэр нь өөрийн эзэмшлийн уурхайгаас ашиглалтын 3 жилийн хугацаанд 401.46 мян.тн хүдэр олборлох ба 2020 онд олборлож овоолгод хадгалсан 24.39%-ийн дундаж агуулга бүхий 55.8 мян.тн хүдэр байгааг баяжуулах үйлдвэрийн ашиглалтын 4 дэх жилд түүхий эд болгон ашиглах юм. Уурхайгаас олборлосон хүдрийг уурхайн талбайд ялган ангилж баяжуулахгүйгээр шууд тээвэрлэж баяжуулах үйлдвэрт хүргэж баяжуулна.

Тус Мөн “Бор-өндөр Уул” ХХК нь уурхайн ам нөхцлөөр 60%-иас дээш агуулгатай хүдрийг 297000төг/тн үнээр худалдахаар тохирсон.

1.4.2 Хайлуур жоншны хүдэр баяжуулах технологи

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн схемийг сонгохдоо баяжигдах шинж чанарын туршилтын үр дүн, үйлдвэрлэлийн хүчин чадал, баяжмалын чанар зэргийг харгалзан үзэхэд флотацийн аргаар баяжуулахад чанарын шаардлага хангасан эцсийн бүтээгдэхүүн болох ФФ97 маркийн жоншны баяжмал гарган авах боломжтой нь технологийн туршилтаар батлагдсан.

Жоншны агуулга, шинж чанараас нь хамааран үечлэн овоолго хийж, хольж жигдрүүлж агуулгаар нь дундчилан бэлдэж хадгалан, хүдрийг холих үед хүдрийн бүтцийн чанарт байнгын хяналт тавина.

Хүдэр баяжуулахдаа цэвэрлэгээний 6 флотаци, хяналтын 2 флотацтай бүдүүвчийг ашиглана.


Баяжуулах үйлдвэрт тэжээх хүдрийн 7 хоногийн нөөц байхаар тооцож өөрийн ордоос хүдэр татан авалтыг хийж байх ба үйлдвэрийн жигдрүүлэх талбайд хуримтлуулан хольж бэлтгэнэ. Бутлах цехийн дэргэд хүдэр жигдрүүлэх талбайд буулгах бөгөөд баяжуулах үйлдвэрт өгөхийн өмнө хүдрийн овоолгоос тогтоосон аргачлалын дагуу хольж агуулгын хувьд жигдрүүлж өгөх юм.

Үйлдвэрийн хүдэр хүлээн авах хэсэгт 2 тусдаа талбайг бэлтгэх бөгөөд “Бор-Өндөр Уул” ХХК-иас худалдан авах өндөр агуулгатай хүдэр болон уурхайгаас шууд ачуулсан агуулга багатай хүдрийг тус тусад нь овоолго үүсгэн хуримтлуулна. Үйлдвэрт тэжээхийн өмнө хүдрийн овоолгуудаас дээж авч агуулгыг нь тодорхойлж байх бөгөөд анхдагч хүдрийн агуулгуудаас нь хамааруулан овоолго тус бүрээс үйлдвэрт өгөгдөх хүдрийн хэмжээг

тохируулж өгөх юм. “Бор-Өндөр Уул” ХХК-ийн уурхайн талбайд бутлагдсан агуулга өндөртэй хүдрийг шууд завсрын бункерт тэжээж өгнө. Харин уурхайн талбайгаас шууд ачуулсан хүдрийг баяжуулах үйлдвэрийн анхдагч хүдэр хүлээн авах бункерт тэжээх бөгөөд хүдэр нь 3 шатны бутлуураар бутлагдсаны дараа завсрын бункерт өгөгдөх бөгөөд завсрын бункерт холилт жигдрүүлэлт хийгдэнэ.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэрийн технологи

№	Үндсэн технологи	Технологийн тайлбар
1	Бутлах хэсэг	Бутлах хэсэг нь хүдрийн шинж чанар хатуулаг, сулралын зэрэг баяжуулалтын үр дүн зэргээс хамааруулан III-шатны бутлалт болон нэг шатны нунтаглалтад орох ба анхан шатны том бутлалтад PE500*750 маркийн хацарт бутлуур -100 мм ширхэглэлтэй болтол бутлан дунд шатны бутлалтад PE150*750 маркийн хацарт бутлуураар бутлагдан -20 мм ширхэглэлтэй болтол бутлагдан доргиур шигшүүрээр шигшигдэн шигшүүрийн дээрх бүтээгдэхүүн конусан бутлуурт орж -3 мм-ийн ширхэглэлтэй болон бутлагдана.
2	Нунтаглалт	. Бутлагдсан нунтаг хүдэр нь нунтаглалтад GMG2436 маркийн бөмбөлөгт тээрэмд орж нунтаглагдан нунтаглалтаас гарсан бүтээгдэхүүн нь мушгиа ангилагч (FLG2000)-д орж ангилагдан том ширхэглэлтэй бүтээгдэхүүн нь буцаж нунтаглалтад орж нарийн ширхэглэлтэй хүдэр нь флотацийн тэжээлийн холигч чанруу орж анхан шатны флотацид өгөгдөнө.
1	Үндсэн флотаци	баяжмалыг 6 шатны цэвэрлэгээний флотацаар оруулж 97%-ийн агуулгатай жоншны баяжмал гарган авах ба баяжмалыг өтгөрүүлэгчид өтгөрүүлэн хатуулгын агуулга 55%-тай болтол өтгөрүүлж, вакум филтрээр 10%-ийн чийглэгтэй болтол нь усгүйжүүлнэ.
2	Хяналтын флотаци	Үндсэн флотацийн хаягдлыг нь 2 шатны хяналтын флотацид оруулах ба анхан шатны хяналтын флотацийн баяжмал бүтээгдэхүүн нь үндсэн флотацид битүү циклээр дахин тэжээгдэнэ. Хяналтын хоёр дахь шатны флотацийн баяжмал нь хяналтын флотаци-I-д ачаалагдах ба хаягдлыг нь шүүн шахах хэсгийн пресс филтрээр усгүйжүүлэн хаягдлын овоолгод хаяна.



Зураг 5. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем



Зураг 6. Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хээрийн судалгааны үед DJI air drone 2025-07-04

1.4.3 Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж

Бутлах хэсгийн тоног төхөөрөмж. Уурхайнуудаас ирсэн өөр өөр агуулгатай хүдрийг тус тусад хүдэр хүлээн авах талбайд овоолго үүсгэн хуримтлуулах бөгөөд үйлдвэрт тэжээхийн өмнө чанарын дундажлалтыг хийнэ. Анхан шатны хүдэр хүлээн авах бункер нь 50 м³-ын багтаамжтай. Бункерийн доор байрлах CG980*1240 маркийн тэжээгүүрээр хүдрийг анхдагч хацарт бутлуурт өгнө. Хацарт бутлуур (PE500*750)-ын тэжээх амсрын хэмжээ нь 500мм х750мм-хэмжээтэй ба тэжээх хүдрийн хамгийн том ширхэглэл нь 500 мм байх бөгөөд 55 кВт-ын хөдөлгүүртэй, цагт 34-68 м³/ц хүртэл бутлах суурилагдсан хүчин чадалтай юм. Бутласан хүдрийг тэжээгч (CG980*1240)-ээр туузан дамжуулагч (TD-65)-т өгөх ба дамжуулагч нь цааш 23 м зайд зөөвөрлөн Дунд шатны хацарт бутлуур (PE150*750)-т тэжээнэ. Хацарт бутлуурын хүлээн авах амсрын хэмжээ нь 150*750 мм байх ба тэжээх хүдрийн хамгийн том ширхэглэл нь 180 мм байх бөгөөд 30 кВт-ын хөдөлгүүртэй, цагт 10-32 м³/ц хүртэл бутлах суурилагдсан хүчин чадалтай. Дунд шатны бутлуурт бутлагдсан хүдэр нь (TD65) маркийн дамжуулагчаар зөөвөрлөгдөн доргиурт шигшүүр (SZ1250)-ээр шигшигдэн шигшүүрийн доорх бүтээгдэхүүн нь нунтаглалтад орж, дээрх бүтээгдэхүүн нь конусан бутлуур (PVV100)-т дахин гүйцээн бутлагдаж нунтаглалтад орно.

Бутлах хэсгийн жигд бус ажиллагааг тооцсон коэффициент $k=0.9$ гэж тооцож цагийн бүтээлийг чадлыг тооцов.

Анхан шатны бутлалт Том бутлалтын хэсэгт жигдрүүлэх талбайгаас 500 мм ширхэглэлтэй хүдэр бутлах цехэд өгөгдөнө гэж тусгав. Хүдрийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ- 500 мм Бутлагдсан бүтээгдэхүүний ширхэглэлийн хэмжээ- 75 мм Бутлалтын ерөнхий зэрэг: $Ser=D_{max}/d_{max}=500/100\approx 5$

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Хүснэгт 7. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ширхэг	Хөдөлгүүр кВт
1	Тэжээгүүр	PG650×2000	2	2х2.2
2	Хяналтын кабенет		1	2.2
3	Туузан дамжуулагч	TD75-6550	1	5.5
4	Цахилгаан туузан дамжуулагч тохируулагч	PDC-650	1	-
5	Бөмбөлөгт тээрэм	MQG2436	1	320
6	Тэжээгүүр	PG500х2500	1	2.2
7	Туузан дамжуулагч	TD75-5050	1	3
8	Булингийн насос	XPA100/100	2	37
9	Операторын хяналтын өрөө			37
10	Гидроциклон	ХСП-Ф450	2	
11	Холигч танк	GB12500×2500	2	2х15
12	Холигч танк	GB/2000х2000	1	7.5
13	Флот-машин хаягдлын	SP-6	10	10х22
14	Флот- машин цэвэрлэгээний	SP-6	14	14х22
15	Химийн бодисын танк	BJW1500х1500	3	3х3
16	Химийн бодисын танк	BIW1250х1250	2	2х2.2
17	Насос	40PV-SP	2	2х5.5
18	Кран	Q-10t	1	27
19	Кран жижиг	Q-3t	1	69
	Нийт			965.9

Баяжмалыг усгүйжүүлэх систем. SF-6 маркийн цэвэрлэгээний флот-машинны баяжмалыг насосын тусламжтайгаар NZ-15 маркийн өтгөрүүлэгчид шахан 40% хатуулагтай болтол өтгөрүүлж, өтгөрсөн баяжмалыг өөрийн урсгалаар CJAH-10 маркийн вакуум филтрээр усгүйжүүлэн чийглэгийн агуулга 10-11%-тай болгон усгүйжүүлж, дамжуулагчаар тээвэрлэн хатаалтын зуухны тэжээх бункерт тэжээж хатаалтад оруулна

Хүснэгт 8. Баяжмал усгүйжүүлэх тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ширхэг	Хөдөлгүүр, кВт
1	Баяжмал шахах насос	2OV-AF		11
2	Өтгөрүүлэгч	NZY-15		5.5
3	Холигч танк	SJ2.0×2.5		2.2
4	Булингийн насос	XPA (2)-65		37
5	Хяналтын өрөөний хэрэглээ			37
6	Филтр пресс	CJAH10/80/30		11+0.75
7	Туузан дамжуулагч	TD75-8063		11
8	Насос	40PV-SP		2х5.5
9	Кран жижиг	Q-3t		6.9
	Нийт			96

Хаягдлыг усгүйжүүлэх хэсгийн үндсэн тоног төхөөрөмж. SF-6 маркийн үндсэн болон хяналтын флот-машинны хаягдлыг насосын тусламжтайгаар холигч чанн руу шахаж, хаягдал булингыг чанад хуримтлуулах бөгөөд чанан дахь зутанг өндөр даралтын насосын тусламжтайгаар усгүйжүүлэх филтр пресст тэжээж, хаягдлыг 18-22%-ийн чийглэгтэй болтол усгүйжүүлэх ба хатуу хаягдлыг дамжуулагчаар тээвэрлэн автосамосвалд ачаална.

Хүснэгт 9. Хаягдал усгүйжүүлэх хэсгийн тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ширхэг	Хөдөлгүүр, кВт
1	Булангийн насос	XPA100/100	2	30
2	Хяналтын өрөөний хэрэгцээ			30
3	Баяжмалын гидроциклон	ХСП-Ф350	2	-
4	Усгүйжүүлэх шигшүүр	VD1536	1	2×2.9

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

5	Туузан дамжуулагч	TD75-6550	1	5.5
6	Өтгөрүүлэгч	NZSG-12	1	3
7	Флокулянт тэжээгч	XNJ-15	1	0.185
8	Флокулянт бэлтгэх танк	XBJ1.0×1.75	1	2.2
9	Химийн бодис шахах насос	IH50-32-125	2	2.2
10	Булангийн танк	XPA(2)-65	3	2×45
11	Хяналтын өрөөний хэрэгцээ		3	45
12	Филтр пресс	XMZ-250/1250	2	2×4
13	Туузан дамжуулагч	TD75-8063	2	2×11
14	Насос	40PV-SP	2	2×5.5
15	Кран жижиг	Q=3t	1	6.9
	Нийт			186.785

1.5 Хаягдлын аж ахуй

Баяжуулах үйлдвэр барьж байгуулахаар төлөвлөсөн газар нь тэгш тал гадаргуу болно. Хаягдлын аж ахуйг бүс нутгийн салхины зүг чиг болон газрын гадаргын нам дор газрыг ашиглан байгуулахад зохимжтой байдаг. Баяжуулах үйлдвэрээс гарах шингэн хаягдлыг усгүйжүүлэн хатуу кек байдлаар гадаад овоолго үүсгэн хадгалах нь зохимжтой ба цаашид хатуу хаягдлыг бүрэн ашиглаж баяжуулан зам болон барилгын тоосго үйлдвэрлэлд ашиглах боломжтой юм.

Үйлдвэрээс 75 мкм-ийн ширхэглэлтэй нунтаг хаягдал гарах ба тус бүс нутаг нь салхитай бүсэд хамаарагддаг. Иймд үйлдвэрийн хаягдлаас үүсэх тоосжилтыг багасгах нь чухал юм. Үйлдвэрээс гарах нунтаг хаягдал хамгийн ихдээ 366.6 тн/хоног байх ба 30 тн даацтай HOWO маркийн машинаар тээвэрлэхэд хоногийн ачаа урсгал 15 ресс байна. Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг үйлдвэрийнхээ зүүн урд хэсэгт байгуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрээс 0.3 км-т $V=77739.6$ м³ эзлэхүүнтэй хуурай хаягдлын даланг зохион байгуулна. Хаягдлыг овоолгод захилах хэлбэрийн овоолгоор овоолох ба байгаль орчин нөлөөлөх сөрөг нөлөөтэй тоосжилтыг бууруулахад анхаарах шаардлагатай. Хаягдлын аж ахуй нь нийт 77739.6 м³ хатуу хаягдлыг агуулж байх ба ойролцоогоор 7500 м² талбай эзлэх ба баяжуулах үйлдвэрийн зүүн урд хэсэгт төлөвлөсөн.



Зураг 7. Хаягдал хадгалах байгууламжийн бүтээн байгуулалтын ажил хээрийн судалгааны үед DJI air drone 2025-07-04

Ордын уул техникийн нөхцөл

Хүдэр болон хөрсний чулуулгийн шинж чанар бат бэхийн үзүүлэлт, ил уурхайн хэлбэр хэмжээ зэрэгт тулгуурлан уулын ажлын механикжуулалтын бүтцийг дараах байдлаар тодорхойллоо.

Хүснэгт 10. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Уулын ажил	Хөрс хуулалт	Хүдэр олборлолт	Шимт Хөрс хуулалт
Ухаж ачихад бэлдэх	ӨТА	ӨТА	ӨТА
Ухаж ачих	Экскаватор	Экскаватор	Экскаватор
Тээвэрлэлт	Автосамосвал	Автосамосвал	Автосамосвал
Овоолго	Бульдозер	Утгуурт ачигч	Бульдозер
Гадаад тээвэр	-	Автомашин	-

Хүснэгт 11. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Гадаргуу дахь урт, өргөн	м	550x148
2	Уурхайн гүн	м	80
3	Доголийн хажуугийн өнцөг	градус	65
4	Доголын өндөр	м	10 (5)
5	Траншейн налуу	%	80/100
6	Хөрсний эзлэхүүн	мян.м ³	1951.89
7	Хүдрийн үйлдвэрлэлийн нөөц	мян.тн	401.46
8	Ордын дундаж агуулга	%	27.32
9	Хүдрийн эзлэхүүн жин	т/м ³	2.6
10	Уурхайн хүрэн дэх уулын цул	мян.м ³	2353.35
11	Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /тн	4.86
12	Ашиглалтын хугацаа	жил	3

1.5.1 Ил уурхайн хүчин чадал, ажиллах горим, ашиглалтын хугацаа

“Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордын талбайд MV-016940 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн дотор хамаарах бодитой (В) зэрэглэлийн нөөц дээр тулгуурлан ТЭЗҮ-г боловсрууллаа. Ордын хүдрийн биетийн зузаан, уналын өнцөг, суналын тогтоц, уул техникийн нөхцөл, нөөц бодсон гүн болон эдийн засгийн үзүүлэлт зэргээс нь харгалзан үзэж ил уурхайн аргаар олборлолт хийхээр төлөвлөсөн.

Уурхайн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаврыг үндэслэн жилд 150.0 мян.тн хүдэр олборлохоор төсөлд тусгав.

Уурхайн жилийн хүчин чадлыг тооцохдоо жилийн дундаж гүнзгийрэлт, хүдрийн биетийн зузаан зэрэг олборлолтын үндсэн нөхцлүүд болон захиалагч байгууллагын санал хүсэлтийг харгалзан үзсэн болно. Техник эдийн засгийн үндэслэлийг ил аргаар олборлон жоншийг өөрийн жоншны хүдэр флотацийн аргаар баяжуулах үйлдвэрт баяжуулан борлуулах зарчмаар ажиллахаар боловсрууллаа.

Уулын ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй явагдах бөгөөд олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас шалтгаалан саатах, төлөвлөгөөт засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцон уурхай нь бодитоор 310 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа.

Хүснэгт 12. Ажлын горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Календарь хоног	хоног	365
2	Цаг агаарын саатал	хоног	15
3	Баяр ёслолын хоног	хоног	16
4	Төлөвлөгөөт засвар	хоног	12
5	Төлөвлөгөөт бус засвар	хоног	12
6	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус засвар, үзлэг	хоног	0.88
7	Тоног төхөөрөмжийн жилд ажиллах бодит хоног	хоног	310
8	Тоног төхөөрөмжийн жилд ажиллах бодит цаг	ээлж	4340

Уурхайн ашиглалтын хугацаа

Хүчин чадалд суурилсан аргаар тооцоход 2.68 жил буюу ойролцоогоор 3 жил гарч байна. Уг ТЭЗҮ-д бид уурхайн ашиглалтын хугацааг компанийн төсөл хэрэгжүүлэх график, уурхайн үндсэн хүчин чадлыг эзэмших хугацаа, уурхайд хаалт, нөхөн сэргээлт хийх хугацааг харгалзан тооцож 3 жил байхаар төлөвлөсөн.

Ил уурхайн хажуугийн тогтворжилт

“Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар 70 м хүртэл гүнтэй олборлоход уурхайн хажуугийн налуугийн өнцөг 50-60 градус байхад тогтвортой байхыг дараах хүснэгтээс сонгов.

Хүснэгт 13. Уурхайн хажуугийн өнцөг

Чулуулаг	Чулуулгийн бат бэхийн коэффициент	<90				
		≤90	≤180	≤240	≤300	≤300

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

Дээд зэргийн бат бөх болон маш бат бөх чулуулаг	15-20	60-65	57-65	53-60	48-54	43-49
Бат бөх болон бөхдүү чулуулаг	8-14	50-60	48-57	45-53	42-48	37-43
Дунд зэргийн бат бөх чулуулаг	3-7	45-50	41-48	39-45	36-46	32-37
Зөөлөндүү бат бөх чулуулаг	1-2	30-43	28-41	26-39	26-36	-
Зөөлөн болон уйрмэг чулуулаг	0.6-0.9	21-30	20-28	-	-	-

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Уурхайн 2020 онд олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан учир уурхайн нээлт хийх шаардлагагүй. Ашиглалтын эхний жилд ил уурхайгаас 1347.3 мян.м³ хөрс хуулж, 150.0 мян.тн хүдэр олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 8.98 м³/тн байна.

Ашиглалтын 2-р жилд 398.24 мян.м³ хөрс хуулж, 150.0 мян.тн хүдэр олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 2.65 м³/тн байна.

Ашиглалтын 3-р жилд ил уурхайг бүрэн олборлон дуусгаж, 1250 м хүртэл гүнзгийрч 206.35 мян.м³ хөрс хуулж, 101.46 мян.тн хүдэр олборлож хөрс хуулалтын дундаж коэффициент 2.03 м³/тн байна.

Хүснэгт 14. Календарчилсан төлөвлөгөө

Жил	Түвшин	Нөөцийн блокын дугаар	Хүдрийн хэмжээ, мян.тн	Дундаж агуулга, %	Жонш, мян.тн	Хөрс хуулалт м ³	Хөрс хуулалтын коэффициент м ³ /тн
1 дэх жил	1320<	В-2	0.92	29.001	0.27	1347.3	8.98
		В-3	17.58	25.227	4.44		
		В-4	0.12	24.419	0.03		
	1320–1310	В-2	5.63	29.001	1.63		
		В-3	17.66	25.227	4.46		
		В-4	0.86	24.419	0.21		
	1310–1300	В-1	1.10	36.145	0.40		
		В-2	14.50	29.001	4.21		
		В-3	17.66	25.227	4.46		
		В-4	4.54	24.419	1.11		
		В-5	1.57	20.568	0.32		
	1300–1290	В-1	13.03	36.145	4.71		
		В-2	17.08	29.001	4.95		
		В-3	17.66	25.227	4.46		
		В-4	10.61	24.419	2.59		
1290–1280	В-5	3.41	20.568	0.70			
	В-5	6.05	16.384	0.99			
	Нийт		150.00	26.617	39.925		
2 дах жил	1290–1280	В-1	14.28	36.145	5.16	398.24	2.65
		В-2	17.08	29.001	4.95		
		В-3	17.66	25.227	4.46		
		В-4	10.61	24.419	2.59		
		В-5	4.51	20.568	0.93		
	1280–1270	В-1	0.10	36.145	0.04		
		В-2	16.81	29.001	4.88		
		В-3	17.53	25.227	4.42		
		В-4	10.61	24.419	2.59		
		В-5	26.18	20.568	5.38		
		В-6	10.10	16.384	1.65		
		С-1	0.22	36.122	0.08		
	С-3	4.31	36.167	1.56			
	Нийт		150.00	25.794	38.692		

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

3 дах жил	1280–1270	В-1	9.96	36.145	3.60	206.35	2.03		
		В-2	0.11	29.001	0.03				
	1270–1260	В-1	2.64	36.145	0.96				
		В-2	6.19	29.001	1.80				
		В-3	7.83	25.227	1.97				
		В-4	10.61	24.419	2.59				
		В-5	18.03	20.568	3.71				
		В-6	0.16	16.384	0.3				
		С-1	18.82	36.122	6.80				
		С-2	7.67	37.532	2.88				
	1260-1250	С-3	0.81	36.167	0.29				
		В-4	1.75	24.419	0.43				
		В-5	1.18	20.568	0.24				
		С-1	10.53	36.122	3.80				
		С-2	5.18	37.532	1.94				
		Нийт	101.46	30.620	31.07				
			401.46	27.321	109.68			1951.89	4.86

Баяжуулах үйлдвэрийн төлөвлөлт

Баяжуулах үйлдвэр нь тасралтгүй ажиллагаатай байх ба Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах, ээлжит засвар үйлчилгээ, зэрэг хүчин зүйлүүдийг тооцон үйлдвэр нь 217 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа.

Хүснэгт 15. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	5208
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Төлөвлөгөөт засварын хоног	8
6	Урсгал засварын хоног	8
7	Жилд ажиллах бодит өдөр	217
8	Жилд ажиллах бодит цаг	5208
9	Үйлдвэрийн цаг ашиглалт %	90
10	Жилд ажиллах бодит цаг	4687
11	Сард ажиллах бодит цаг	391
12	Цагийн хүчин чадал, тн/ цаг	32.00
13	Хоногийн хүчин чадал, тн/хоног	768
14	Сарын хүчин чадал, тн/сар	12500
15	Жилийн хүчин чадал, тн/ жил	150000

Үйлдвэрийн хүдэр хүлээн авах хэсэгт 2 тусдаа талбайг бэлтгэх бөгөөд “Бор-Өндөр Уул” ХХК-иас худалдан авах өндөр агуулгатай хүдэр болон уурхайгаас шууд ачуулсан агуулга багатай хүдрийг тус тусад нь овоолго үүсгэн хуримтлуулна.

Үйлдвэрт тэжээхийн өмнө хүдрийн овоолгуудаас дээж авч агуулгыг нь тодорхойлж байх бөгөөд анхдагч хүдрийн агуулгуудаас нь хамааруулан овоолго тус бүрээс үйлдвэрт өгөгдөх хүдрийн хэмжээг тохируулж өгөх юм.

“Бор-Өндөр Уул” ХХК-ийн уурхайн талбайд бутлагдсан агуулга өндөртэй хүдрийг шууд завсрын бункерт тэжээж өгнө. Харин уурхайн талбайгаас шууд ачуулсан хүдрийг баяжуулах үйлдвэрийн анхдагч хүдэр хүлээн авах бункерт тэжээх бөгөөд хүдэр нь 3 шатны

Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Шашир-Оргил” ХХК-ийн “Цагаан чулуут уул” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах, баяжуулах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2026 он

бутлуураар бутлагдсаны дараа завсрын бункерт өгөгдөх бөгөөд завсрын бункерт холилт жигдрүүлэлт хийгдэнэ.

Үйлдвэр нь цаашид 15 жилийн хугацаанд ашиглагдах бөгөөд өөрийн ордын нөөцийн зэргийг ахиулж, үйлдвэр тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.

№	Хүдэр нийлүүлэх компанийн нэр	Ашиглагдах жил												
		1			2			3			4(2020 онд олборлосон хүдрийн овоолго)			Нийт
		Хүдэр, мян. Тн	Дундаж агуулга, %	Эрдэс мчн. Тн	Хүдэр, мян.тн	Дундаж агуулга, %	Эрдэс мчн. Тн	Хүдэр, мян.тн	Дундаж агуулга, %	Эрдэс мчн. Тн	Хүдэр, мян.тн	Дундаж агуулга, %	Эрдэс мчн. Тн	
“Шашир Оргил” ХХК- ийн өөрийн уурхайгаас гарах хүдэр														
1	“Шашир Оргил” ХХК	150.0	26.617	39.93	150	26.594	38.69	101.46	30,620	31.07	55.8	24.391	13.61	401
Бор -Өндөр Уул ХХК-иас худалдан авах хүдэр														
2	“Бор - Өндөр” Уул ХХК	37.5	60	22.50	37.5	60	22.50	37.5	60	22.50	37.5	60	22.50	150.00
Баяжуулах үйлдвэр тэжээх хүдэр														
1	“Шашир Оргил” ХХК	11.39	26.617	29.65	111.31	26.594	29.60	117.71	28.409	33.44	109.6	26.069	28.57	450.0
2	“Бор - Өндөр Уул” ХХК	38.61	60.0		38.69	60,0	23.21	32.29	60.0	19.38	40.41	60.0	24.25	150.0
	Нийт	150	35.21	52.82	150.0	35.21	52.82	150.0	35.21	52.82	150.0	35.21	52.82	600.0

1.5.2 Өрөмдлөг, тэсэлгээ

Өрөмдлөгийн ажил

Доголын талбайг өрөмдлөгт бэлтгэхдээ талбайд буй саад болох тоног төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Өрөмдлөгийн ажлын төслөөр (паспорт) цооног бүрийн байршил, гүний хэмжээг тогтооно. Хяналтын хэмжилтээр ажлын хэрэгжилтийг тодорхойлох ба өрөмдөх торны зай, гүний зөрүү нь 0.1 м – ээс хэтрэхгүй байх ёстой. Цооног янз бүрийн шалтгаанаар нурж гүн нь хорогдох зэрэг тохиолдолд дахиж өрөмдлөг хийж засварлана..

Бусад ажиллагаанууд өрөмдлөгөөс шалтгаалан зогсохгүй байх, өрөмдлөгийн бүтээл өндөр, өртөг зардал хямд байх нь өрмийн төхөөрөмжийн ажлын зохион байгуулалтын зорилго юм. Бэлтгэл ажил ба өрөмдлөгийн блок дахь өрөмдөх ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээг чиглүүлдэг. Өрмийн төхөөрөмжийг ажлын шинэ байршилд шилжүүлэх, талбай засах, гэрэлтүүлгийн зориулалтаар цахилгаан хангамжийг бүрдүүлэх, цооногийн байрлалын тэмдэглэгээ хийх зэрэг нь бэлтгэл ажиллагаанд хамаарна.

Тэсэлгээний ажил

Уг ордын чулуулгийн физик, механикийн шинж чанараас авч үзэхэд дунд зэрэг тэслэгдэх ангилалд хамаарагдана. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий ажил үйлчилгээ эрхэлдэг мэргэжлийн компаниар хийлгэх ба тэсэлгээний үед дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм журам зааврыг нарийн чанд сахиж ажиллана. Өрөмдлөг

тэсэлгээний ажлыг 5 м өндөртэй доголд явуулна. Уулын ажлын төлөвлөлтийн дагуу тэсэлгээний блокийн өргөн нь 8 эгнээ, 3.5×3.0 м торны хэмжээтэйгээр өрөмдлөг тэсэлгээний ажил явуулна. Нэг цооногт орох тэсрэх бодисын хэмжээ 23.35 кг байх ба нэг удаагийн тэсэлгээнд 17800.0 кг тэсрэх бодис хэрэглэнэ.

1.6 Дэд бүтэц

1.6.1 Уурхайн барилга байгууламж

Уурхайн оффис, удирдлагын байр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа, нийтийн хурал, цуглаан, цаг үеийн шуурхай мэдээлэл зэргийг энд зохион байгуулна. Оффис нь тэнхлэгээрээ 36 м х 10 м хэмжээтэй төмөр бетон суурь, сэндвичин хана, дээвэртэй барилга болно.

Уурхайн барилга байгууламжууд нь орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон ажилчид ая тухтай орчин нөхцөлд ажиллах боломж бололцоог олгосон тохилог, өвөрмөц шийдэлтэй байхын зэрэгцээ монгол улсын стандарт, барилгын норм ба дүрэмд нийцүүлсэн байх юм. Дараах барилга байгууламжуудыг байгуулах шаардлагатай.

- Уурхайн засварын цех
- Авто граж
- Сэлбэг агуулах
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах
- Уурхайн ШТС
- Уурхайн харуулын пост

Уурхайн ШТС. ШТС нь уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй газарт байрласан байх шаардлагатай ба автосамосвал болон хийн дугуйт хүнд машин механизмуудыг шатахуун түлшээр хангахад ашиглагдах. Цаг хугацаа бага зарцуулж, түлш шатахууны алдагдалгүй байлгах үүднээс уурхайн талбай дээр өндөр хүчин чадалтай шахуургатай шатахуун түргэн шахах системийг ашиглаж байна.

Засвар техникийн үйлчилгээ, агуулахын аж ахуй. Засвар механикийн цех нь угаах, задаргаа хийх хэсэгтэй, угаах ба механик тасагтай, слесарь угсралтын хэсэг, засварлагдсан агрегат, нэгжүүдийн угсралтыг турших шалгах хэсэг, цахилгаан ба хийн гагнуурын хэсэг, багаж хэрэгслийг хадгалах, хуваарилах, тараах хэсгүүдтэйб Засвар механикийн цехийн ажилтан, ажилчдын нийт тоог 16 хүн байхаар байна.

Тэсрэх материалын агуулах. Тэсрэх бодисын агуулахын талбай дээр тэсэлгээний хэрэгсэл ба тэсрэх бодис хадгалах зориулалтын агуулахууд, мөн тэсрэх бодисыг ачааны машин дээр ачих ачилтын байгууламжтай. Тэсрэх материалын агуулахыг уурхайн нэг сарын хэрэгцээг хангах багтаамж бүхий буюу 50 тн тэсрэх бодис багтах хэмжээтэй байхаар хийсэн. Тэсрэх бодисын агуулахыг уурхайн зүүн урд талд уурхайн гадна хүрэнээс “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасны дагуу 1.6 км зайд байгуулсан.

1.6.2 Цахилгаан хангамж

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийг Батноровын дэд станцаас 35кВ-ын шугам татан хангасан байна. Өндөр хүчдэлийн шугамын нийт трассын урт 11 км үүнээс 0.45км нь кабель шугам байна. Үйлдвэрлэлийн талбайд цахилгаан хэрэглэгч объектууд нь баяжуулах үйлдвэр, үйлдвэрийн оффис, үйлдвэрийн ажилчдын кемп, засвар механикийн цех, ШТС зэрэг байна

1.6.3 Дулаан хангамж

Үйлдвэрийн халаалтын системийг шийдэхдээ цехэд DZL маркийн нам даралтын зуух хэрэглэнэ. Уурхайн дулаан хэрэглэгчдэд баяжуулах үйлдвэр, засвар механикийн цех, захиргаа, шатахуун түгээх станц, цахилгааны дэд станц, тосгоны сууцнууд багтана. Уурхайн халаалтын систем нь дулааны зуухаар ажиллана.

1.6.4 Усан хангамж

Уурхайн ус хангамжийн эх үүсвэрт өөрийн талбайд худаг гаргаж ашиглах бөгөөд худгийн ундарга нь 1.5-3.0 л/сек.

Уурхайн усны эх үүсвэрт хүн амын унд ахуйн усны эх үүсвэрээр гүний худгаар, харин техникийн усны эх үүсвэрээр хөрсний болон олборлолтоос шүүрч гарч байгаа усыг зам талбайн усалгаа, ногоон байгууламжийн усалгаанд ашиглана. Усыг зүй зохистой ашиглахад хөрсний шүүрлийн ус, зумфнээс зайлуулагдсан усыг хуримтлуулан тунгааж ашиглана.

1.7 Төслийн эцсийн бүтээгдэхүүн

1.7.1 Элементийн шинжилгээ, металлын баланс

Нэр- Хайлуур жоншны хүдэр

Марк- ФФ97

Олон улсын нэршил- FO

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Газрын гадаргуу: Хэнтийн уулархаг мужийн өмнөд Улзын ойт хээрээс хээрийн бүс рүү шилжих хэсэг дээр байрладаг. Гадаргуу нь намхан уул, гүвээ толгодорхог, хэрчигдэл багатай, өргөн хөндий хоолой хосолсон онцлогтой. Дэлгэрхаан уул 1594.0 м, Хараат уул 1311.0 м, Сайхан уул 1482.5 м зэрэг өндөр уулнууд байдаг ба дүүргийн харьцангуй өндөршилт нь 1130-1280 м байдаг.

Усан сүлжээ: Тухайн дүүрэг тогтмол урсгалтай Хэрлэн, Онон, Улз зэрэг олон тооны гол горхи байдаг. Холбоо нуур, Цагаан нуур зэрэг бага хэмжээний нууруудтай. Талбайн ойролцоо байх ундны хамгийн сайн ус нь Харзтайн баруун, зүүн булаг, Дэлгэр булаг зэрэг ундарга сайтай булаг элбэг байдаг. Өрөмдмөл болон гүний худаг ховор ч усны чанар сайн, ундарга сайтай тул энэ дүүргийн ахуйн хэрэгцээний усны үндсэн гол эх үүсвэр нь дээрх булгууд болдог. Гүний усны тэжээгч эх үүсвэр нь хурын уснаас хамааралтай. Хур тунадас жилд дунджаар 276 мм унадаг ба үүний 85-90% нь зуны улиралд орно.

Цаг агаар, уур амьсгал: Төслийн хүрээнд агаарын чанарын үзүүлэлтийг хяналт мониторингийн байнгын 2 цэг дээр ажиглаж байдаг бөгөөд төслийн талбайн орчны агаарын чанар MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээнээс хэтрээгүй. Төслийн талбайн бүсэд PM2.5 ширхэглэгтэй тоосны нягтшил 25-аас 42 мкг/м³, PM10.0 ширхэглэгтэй тоосны нягтшил 28-аас 46 мкг/м³, ажлын болон амралтын байрны доторх орчин хүний эрүүл мэндэд нийцтэй, стандартын хэмжээнд байна.

Хөрсөн бүрхэвч: Батноров сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг шинж чанар газар зүйн байршил хөрс үүсгэгч нөхцөлөөр нь: 1. Долгиорхог тал, хээрийн ба өргөн хөндийн хөрс 2. Голын хөндийн, нугын хээршсэн хөрс 3. Уулархаг, уулын хөрс 4. Хээрийн элсэрхэг, хүрэн хөрс гэж хуваана. Долгиорхог хээр талын ба өргөн хөндийн хөрс зонхилох хувийг эзэлнэ.

Төслийн талбайн хувьд авч үзвэл талбайн дунд хэсэгт хар хүрэн хөрстэй бөгөөд бусад хэсгээрээ уулын хүрэн хөрс тус тус хамаарна.

